



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 09 сарын 12 өдөр

Дугаар 284

Улаанбаатар хот

“Солонго экспресс” ХК-д “Еврофё Азия” ХХК-ийг
нэгтгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 7.1, 34.1.7, Компанийн тухай хуулийн 20, 42.4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Солонго экспресс” ХК-ийн нийт гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 156,523 ширхэг хувьцааг нэгдэж буй компанийн хөрөнгөд оногдох нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 451,286 ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэн нийт 607,809 ширхэг гаргасан нийт хувьцааг үнэт цаасны нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Саруул/, хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Энэхүү тогтоолын нэгд заасан нэмж гаргаж буй 451,286 ширхэг энгийн хувьцааны өмчлөх эрхийг дор дурдсан хуваарийн дагуу хөрвүүлэн бүртгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

Д/д	Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо
1	Себастиен Марнёр	225,643
2	A.E.R Holding	90,257
3	Отгоншарын Бат-Эрдэнэ	135,386
	Нийт	451,286

3. “Солонго экспресс” ХК-ийн оноосон нэрийг “Еврофё-Азия” ХК болгон өөрчилж үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар /Б.Саруул/, Хөрөнгийн биржийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/,

үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.


4. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орсонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Солонго экспресс” ХК /Ч.Болортуяа/-д үүрэг болгосугай:

1/ “Солонго экспресс” ХК-д “Еврофё Азия” ХХК-ийг нэгтгэсэнтэй холбогдуулан хууль тогтоомжид заасны дагуу өөрчлөн байгуулж, санхүүгийн тайлан бүртгэлд холбогдох хууль, тогтоомжийн дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, өөрчлөлтийг тэмдэглүүлэн Хороонд ирүүлэх;

2/ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

3/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ыг мөрдөж ажиллах.

5. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН